



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 7 сарын 4 өдөр

Дугаар 1/258

Мандалговь

Орчны цэвэрлэгээ, сэг зэм устгал,
халдваргүйтгэх шуурхай ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 (а), Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7 дугаар зүйлийн 7.3, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 02 тоот албан даалгаврын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Нийтийн эзэмшлийн газар нутаг, улс орон нутгийн чанартай замын ойролцоо болон бэлчээрт үхсэн мал амьтны сэг зэм их болж байгаль орчин бохирдон, хүн, мал амьтны халдварт өвчин тархах эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлж орчны цэвэрлэгээ, сэг зэм устгалын ажлыг 2019 оны 7 дугаар сарын 5, 6-ны өдөр зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Хоёр. Орчны цэвэрлэгээ, сэг зэм устгал, халдваргүйтгэлийн ажлын төлөвлөгөө гарган зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Ш.Мөнхдүүрэн), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Н.Гантулга)-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ж.МӨНХЧУЛУУН

480130730